



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/554

Алтай хот

**Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт
үзүүлсэн сургууль, багш, сурагчдыг
урамшуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 41.2.7 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.1.6 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн сургууль, багш, сурагчдыг урамшуулах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Урамшуулалд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг Боловсролын газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4.Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/559 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн сургууль, багш, сурагчийг
урамшуулах төсвийн зардал

д/д	Зарцуулалт	Ангилал	Хүний тоо	Нэг хүнд ногдох мөнгөн дүн	Нийт
1	ЭЕШ-2021	Ментор багш	24	200000	4800000
		800-сурагч	3	1000000	3000000
		800-багш	3	1000000	3000000
		Лабортори 1 дүгээр сургууль 1-р байр	1	3000000	3000000
		Хантайшир эрдэм цогцолбор сургууль 2-р байр	1	2500000	2500000
		Тайшир сумын ерөнхий боловсролын сургууль 3-р байр	1	1500000	1500000
		Анги-1-р байр	1	100000	1000000
		Анги-2-р байр	1	800000	800000
		Анги-3-р байр	1	400000	400000
Нийт дүн: 20,000,000					